

“ДОТУУР ХОЛБООНЫ СЕРВЕР ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ”

ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: *Дотуур холбооны сервер төхөөрөмж нийлүүлэх*

**Харьцуулалт/
гэрээний дугаар:** *ТБ/201802050*

Төсөв: *28,000,000 төгрөг*

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Төрийн банк нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос *Дотуур холбооны сервер төхөөрөмж нийлүүлэх* тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг *2018 оны 10-р сарын 24-ний өдрийн 11 цаг 00* минутаас өмнө *Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д цахим хэлбэрээр* ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан *тухайн өдрийн 11 цаг 20 минутанд* нээнэ.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичгийг *Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)* -ээс авна.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
 - 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Үнийн санал баталгаажуулж ирүүлнэ /маягтын дагуу/. 2. Бараа нийлүүлэх хуваарь баталгаажуулж ирүүлнэ /маягтын дагуу/. 3. Хүчин төгөлдөр Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ. 4. Татварын цахим тайлангийн системээс авсан татварын тодорхойлолтыг ирүүлэх ба энэхүү тодорхойлолтын хүчинтэй хугацаа нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна. Монгол Улсын эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Тодорхойлолтын доод хэсэгт байрлах баркод болон тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаар гаргацтай байх шаардлагатай. 5. Байгууллагын тухай танилцуулга ирүүлнэ. 6. Нийлүүлэх барааны дэлгэрэнгүй танилцуулга /Зураг болон нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр харьцуулсан хүснэгт гаргаж баталгаажуулан ирүүлнэ. Аль нэг зүйл заалтыг орхигдуулаагүй байх/ 7. Чанарын баталгаат хугацаа 1 жил түүнээс дээш байна /Баталсан албан бичиг ирүүлнэ/. 8. Баталгаат хугацаанд гарсан доголдлыг өөрийн зардлаар шуурхай засварлах, арилгахыг зөвшөөрсөн албан бичиг. 9. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг эх хувиар ирүүлэх ба энэхүү тодорхойлолтын хүчинтэй хугацаа нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна. 10. Харьяа дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн өргүй тухай тодорхойлолтыг эх хувиар ирүүлнэ. 11. Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолтыг эх хувиар ирүүлнэ. 12. Улсын бүртгэлийн гэрчилгээн дээр бүртгэгдсэн болон харилцагч банк болгоноос хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх тодорхойлолт авч ирүүлнэ. 13. Төрийн банкны зүгээс тухайн тендерт оролцогчийн талаар харилцагч банк, харьяа татвар, шүүх, нийгмийн даатгалын хэлтэс болон бусад байгууллагад хандаж лавлагаа хүсэхэд татгалзахгүй тухай зөвшөөрсөн албан бичиг ирүүлнэ. 14. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд санал болгож буй барааг гэрээний үнэ, хугацаанд багтаан техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэхийг баталсан албан бичиг ирүүлнэ. 15. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг ирүүлнэ.

	<p>16. Тендерт оролцогчийн ирүүлсэн үнийн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ.</p> <p>17. Монгол дахь албан ёсны борлуулагчийн гэрчилгээний хуулбарыг баталгаат орчуулгын товчоогоор Монгол хэлрүү орчуулсан орчуулгын хамт ирүүлнэ. Гэрчилгээний хүчинтэй хугацаа нь тендерийн хүчинтэй хугацаанд хүчин төгөлдөр байх.</p> <p>18. Нийлүүлэх бараа бүтээгдэхүүн нь олон улсын стандартын шаардлагад нийцсэн болохыг баталсан албан бичиг ирүүлнэ.</p> <p>19. Төхөөрөмж болон програмийг суурилуулах, нэвтрүүлэх чадвартай байх. /Баталсан албан бичиг ирүүлнэ/</p> <p>20. Нийлүүлэлтийн дараах засвар үйлчилгээг шуурхай гүйцэтгэх үйлдвэрлэгчийн сертификаттай эсхүл түүнтэй дүйцэхүйц сетификаттай мэргэшсэн боловсон хүчний мэдээллийг ирүүлнэ. /Сертифик, цахим үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтэрийн хуулбар болон НД8 маягтыг сүүлийн 6 сараар ирүүлнэ. Нийгмийн даатгалын дэвтэрийн 1-р хуудас болон 2018 онд төлсөн шимтгэл, даатгуулагчийн ажил, албан тушаалын өөрчлөлтын тэмдэглэл зэрэг мэдээллүүдийг агуулсан хуудсуудыг заавал ирүүлнэ./</p> <p>21. 2016 болон 2017 онуудын аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй төхөөрөмж гэрээгээр нийлүүлж байсан туршлагын мэдээллийг дэлгэрэнгүй ирүүлнэ. Гэрээ, гэрээний хавсралт, актыг заавал хавсаргаж ирүүлнэ /Зарлагын баримтыг акт гэж тооцохгүй/.</p> <p>22. 2017 оны жилийн эцсийн баталгаажсан санхүүгийн тайлан ирүүлнэ /Сангийн яамны И-Баланс цахим системд шивэгдэж баталгаажсан байх/.</p> <p>23. Ашигтай ажилласан байх жилийн тоо: 2017 он.</p> <p>24. Борлуулалтын орлогын хэмжээ: 2017 оны борлуулалтын орлогын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.</p> <p>25. Гадаад хэл дээрх бүх материалыг Монгол хэл рүү баталгаат орчуулгын товчоогоор орчуулан ирүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Тендерийн баримт бичгийг ТООЗ 1.1-д заасан дарааллын дагуу эмхэтгэж ирүүлнэ. • Тендерийн хэл нь Монгол хэл дээр байна. • Хувилбарт үнийн санал ирүүлэхгүй. • Гадаадын этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй. • ТШӨХ-т заасан баримт бичгүүдээс аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд татгалзах үндэслэл болно.
<p>ТООЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>2018 оны 10-р сарын 24-ний өдрийн 11 цаг 00 минутаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д цахим хэлбэрээр хүлээн авна.</p>

	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийн цагаар тоологдох, Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ, нэг файлын хэмжээ зэрэг нь хязгаарлагдмал байдаг зэргийг анхаарна уу. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Холбоочдын гудамж, Төрийн банкны төв 2-р байр, 2-р давхар, 202 тоот өрөө.</p> <p>Огноо: 2018 оны 10-р сарын 24-ний өдөр.</p> <p>Цаг: 11 цаг 20 минут</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй</p>

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. **Барааны тодорхойлолт:**

Нийлүүлэгдэх бараа болон холбогдох үйлчилгээ нь дор дурьдсан барааны тодохойлолт, техникийн үзүүлэлтийг хангасан байна.

Дотуур холбооны станц IP PBX-ын төхөөрөмжийн техникийн тодорхойлолт

№	Бараа болон холбогдох үйлчилгээний нэр	Техникийн тодорхойлолт болон стандарт	Тоо ширхэг
1	РВХ хосолсон төхөөрөмж	<p>Нийлүүлэх төхөөрөмж нь Grandstream UCM6510 төхөөрөмж эсхүл түүнтэй дүйцэхүйц доорхи үзүүлэлтэд нийцэж байх ёстой.</p> <p>SIP Endpoints - Up to 2000 Current Calls - Up to 200 Conference - Up to 60 IVR - UP to 5 layers</p> <p>CPU – 1 GHz quad-core Cortex A9 processor RAM – 1 GB DDR3 Ram, 32GB Flash 1 Integrated T1/E1/J1 interface 2PSTN trunk FXO ports 2 analog telephone/Fax FXS ports with lifeline capability NAT Router - Yes (user configurable) Intergrated Ports - USB, SD 128x32 dot matrix graphic LCD Reset button Layer 3 QoS, Layer 2 QoS Rack mount Network Protocols - TCP/UDP/IP, RTP/RTCP, ICMP, ARP, DNS, DDNS, DHCP, NTP, TFTP, SSH, HTTP/HTTPS, PPPoE, SIP (RFC3261), STUN, SRTP, TLS, LDAP, HDLC, HDLC-ETH, PPP, Frame Relay Media - SRTP, TLS, HTTPS, SSH Advanced Defense - Fail2ban, alert events, Whitelist, Blacklist, strong password based access control.</p> <p>Power Supply Input: 100-240VAC, 50-60Hz; Output: DC+12VDC, 1.5A</p> <p>Caller ID Bellcore/Telcordia, ETSI-FSK, ETSI-DTMF, SIN 227 – BT, NTT Japan</p> <p>Call Center Multiple configurable call queues, automatic call distribution (ACD) based on agent skills/availability/busy level, in-queue announcement Call park, call forward, call transfer, DND, DISA, ring group, pickup group, blacklist, paging/intercom Compliance • FCC: Part 15 (CFR 47) Class B, Part 68 • CE: EN55022 Class B, EN55024, EN61000-3-2, EN61000-3-3, EN60950-1, TBR21, RoHS • A-TICK: AS/NZS CISPR 22 Class B, AS/NZS CISPR 24, AS/NZS 60950, AS/ACIF S002 • ITU-T K.21 (Basic Level); • T1: TIA-968-B Section 5.2.4 • E1: TBR12/TBR13, E1: AS/ACIF</p>	2

2	PBX cluster холболтын төхөөрөмж	<p>Нийлүүлэх төхөөрөмж нь Grandstream HA100 эсхүл түүнтэй дүйцэхүйц доорхи үзүүлэлтэд нийцэж байх шаардлагатай</p> <p>INTERFACES: BACK PANEL Analog Telephone FXS Ports : 2 ports PSTN Line FXO Ports : 2 ports T1/E1 Interface : 1 port Network Interfaces : 1 LAN/ 1WAN RS-485 : 2; 1 for Primary UCM6510; 1 for Secondary UCM6510 Reset Switch : Yes Universal Power Supply : DC Power Port</p> <p>INTERFACES: FRONT PANEL Analog Telephone FXS Ports : 4; 2 FXS A, 2 FXS B PSTN Line FXO Ports : 4; 2 FXO A, 2 FXO B T1/E1 Interface : 2 ports; T1/E1 A, T1/E1 B Network Interfaces : 2 LAN, 2 WAN LED Indicators :Power, T1/E1, FXS, FXO, LAN, WAN</p>	1
3	PBX-н төлбөр тооцооны программ	<p>PBX-н Billing software:</p> <ul style="list-style-type: none"> • Anthias STAT for all extensions • Оффисын утасны дугаар, харилцаа холбооны урсгалыг бүртгэж, хөдөлгөөн, төлбөр тооцоо, дугаарын гарах ярианы лимит тохируулах, лимитээс илүү гарсан тохиолдолд дуудлага хязгаарлах, дуудлагын статистик гардаг байх. • Хэрэглэгчийн нэгдсэн баазын зохион байгуулалттай байх. 	
4	PBX-н цогц шийдлийн нэвтрүүлэлт	<p>Нэвтрүүлэлтийн ажил:</p> <ul style="list-style-type: none"> • PBX хосолсон төхөөрөмж суурилуулж тохируулна. • PBX cluster холболтын төхөөрөмж суурилуулж тохируулна. • PBX-н төлбөр тооцооны программ нэвтрүүлнэ. <p>Эдгээрийг цогцоор нь нэвтрүүлж, ажилд оруулан хүлээлгэн өгнө</p>	

2. Стандарт:

Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.

3. Баглаа, боодол:

Бараа нь хайрцаг сав, баглаа боодолтой, шинэ байна. Баглаа боодол бүрийн гадна талд бүтээгдэхүүний нэр, тоо ширхэгийг тэмдэглэсэн товъёог наасан байна.

4. Бараа хүргэх газар:

Барааг захиалагчийн товлосон газар хүргэж, угсарч, төрийн банкны бараа, ажил үйлчилгээ хүлээлцэх актаар хүлээлгэн өгч гарын үсэг тамга тэмдэгээр баталгаажуулна. /Улаанбаатар хотод хуваарьтай барааг хүргэж, угсарч хүлээлгэн өгнө. Орон нутагт хуваарьтай барааг ачаа тээврийн газар хүргэж ачилцаж өгнө./

5. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

№	Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
						Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
	1	2	3	4	5	6	7	8
1	РВХ хосолсон төхөөрөмж	Техникийн тодорхойлолт 1-т зааснаар.	2	Ширхэг	Техникийн тодорхойлолт 4-т зааснаар.	1	40	
2	РВХ cluster холболтын төхөөрөмж		1			1	40	
3	РВХ-н төлбөр тооцооны программ		1			1	40	
4	РВХ-н цогц шийдлийн нэвтрүүлэлт		1			1	40	

Жич:

1. Нийлүүлж буй барааг хүргэж өгөх, ачиж буулгах, тээвэрлэх, угсарч суурилуулах ажыг нийлүүлэгч тал бүрэн хариуцна.
2. Барааг авахын өмнө туршилтын журмаар загвартай танилцаж болно. Хэрэв туршилтын журмаар загвартай танилцах болвол Захиалагч талын товлосон байршил, хугацаанд Нийлүүлэгч тал хариуцан загварыг танилцуулна.

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа нь техникийн тодорхойлолтод заасан жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээ байгуулсны дараа гэрээний үнийн дүнгийн **40** хувийг, барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн гэрээний үнийн дүнгийн үлдэгдэл **60** хувийг тус тус төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9) 9.1. Алданги оногдуулах хувь: **0.5**
- Алдангийн нийт дүн: **10**

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын __-наас _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх).
Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]